



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/134

Мандалговь

Дундговийн толь 1,2-р боть ном бүтээх зөвлөх үйлчилгээний зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.8 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн түүхт 80 жилийн ойг тохиолдуулан түүх, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор “Дундговийн толь 1,2-р боть” ном бүтээх зөвлөх үйлчилгээний зардалд 20,0 сая (Хорин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зөвлөх үйлчилгээний зардалд зарцуулах 20,000,000 сая (хорин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг Даргын Тамгын Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100315